

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Технологид суурилсан хэрэглэгчтэй харилцах менежментийн үйлчилгээ үзүүлэгч "Salesforce.com" компани дата шинжилгээний "Tableau Software" компанийг худалдан авах болсноор энэ долоо хоногт мэдээлэл технологийн компаниудын хувьцааны ханш их хэмжээний өсөлт үзүүлжээ.

АНУ-ын газрын тосны нөөц нэмэгдсэнтэй холбоотойгоор газрын тосны үнэ 4 орчим хувиар буураад байсан бол Пүрэв гарагт Персийн булангийн ойр АНУ-ын газрын тос тээвэрлэгч хоёр ч хөлөг онгоц халдлагад өртөж, газрын тосны ханш өсөхөд нөлөөлөв. АНУ уг халдлагад Иран улсыг буруутгаад байгаа юм. Үүнээс үүдэн өндөр хүлээлт үүсгээд байсан дипломат хүчин чармайлт АНУ, Иран хоорондын зэвсэгт мөргөлдөөнийг зогсоож чадахгүй нь гэсэн айдас шинжээчдийн дунд бий болоод байна.

АНУ, БНХАУ хоорондын худалдааны хэлэлцээр хойшлов. АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп БНХАУ-ыг энэ оны эхээр санал болгосон нөхцөлийг хүлээн зөвшөөрөх хүртэл худалдааны яриа хэлэлцээрийг хойшлуулжээ. Тэрбээр "БНХАУ-тай нэг бол маш сайн гэрээ хийнэ эсвэл огт хийхгүй болох"-ыг онцолсон байна.

АНУ-ын инфляцийн түвшин суларснаар тус улсын 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын өгөөж буурлаа.

Европ: Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа.

ХБНГУ-ын Канцлер Ангела Меркель ОХУ-аас байгалийн хийн хоолой татах болсонтой холбогдуулан АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп Герман улсад хориг арга хэмжээ авна гэж сүрдүүлжээ. Энэхүү төсөл Германыг ОХУ-аас хэт хамаарал бүхий байдалд оруулна гэж анхааруулжээ. Нөгөө талаас АНУ Герман руу шингэрүүлсэн байгалийн хий нийлүүлэх хүсэлтэй байгаа юм.

Европын эдийн засагчид "Brexit" хэлэлцээрийг Европын бүсийн хамгийн том эрсдэлд тооцож байна. Их Британийн Ерөнхий сайд асан Тереза Мэйн өргөн барьсан "Brexit" хэлэлцээрийн төсөл Парламентаар гурван ч удаа няцаагдаж, Европын Холбоо "Brexit" хэлэлцээрийн товыг 10-р сарын 31 болгож хойшлуулаад байгаа юм. Үүнтэй холбоотойгоор Их Британийн Ерөнхий сайдад нэр дэвшигчид Их Британийн телевизийн сувгаар мэтгэлцээнд оролцож, "Brexit" хэлэлцээрийн үйл явц, цаашид Европын Холбооноос гарах асуудлыг хэрхэн чиглүүлэх талаар байр сууриа илэрхийллээ. Тус улсын улс төрийн тодорхойгүй байдлаас үүдэн фунтийн ханш ам. долларын эсрэг 1 хувиар суларчээ. Мөн өнгөрсөн 4-р сард Их Британийн эдийн засаг огцом удааширсан үзүүлэлттэй байна. Тэр дундаа тус улсын авто машины үйлдвэрлэл огцом буурчээ.

Япон: 2019 оны 1-р улиралд Японы Засгийн газрын худалдан авалт нэмэгдсэнтэй холбоотойгоор тус улсын ДНБ урьдчилан таамаглаж байсан хэмжээг давж, 2.2 хувиар өсжээ.

Эх сурвалж: Troweprice.com, BloombergTv.mn

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,689.76	0.63% ▲
Dow Jones	АНУ	26,089.61	0.41% ▲
S&P 500	АНУ	2,886.98	0.47% ▲
Nasdaq	АНУ	7,796.66	0.70% ▲
S&P/TSX	Канад	16,301.91	0.44% ▲
FTSE 100	Их Британи	7,345.78	0.19% ▲
S&P/ASX 200	Австрали	6,554.00	1.71% ▲
Nikkei 225	Япон	21,116.89	1.11% ▲
Hang Seng	Хонг Конг	27,118.35	0.57% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	111.52
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	100.61
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	99.76
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	110.42
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.43
DBM' 2023	USD	7.250%	102.81
TDBM' 2020	USD	9.375%	103.48

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.280	-0.13 ▼
Libor 3M	2.400	-0.05 ▼
Libor 6M	2.270	-0.10 ▼
Libor 1YR	2.250	-0.10 ▼
US 2YR Bond	1.865	-0.02 ▼
US 3YR Bond	1.809	-0.05 ▼
US 5YR Bond	1.859	-0.03 ▼
US 10YR Bond	2.105	-0.01 ▼

Валютын ханш /төг/

Валют	2019.06.14	Өөрчлөлт
USD	2,654.41	0.09% ▲
CNY	383.35	-0.13% ▼
EUR	2,996.03	0.32% ▲
RUB	41.21	1.05% ▲
KRW	2.24	0.00% ▲
JPY	24.53	0.33% ▲
CAD	1,989.81	0.16% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,341.70	0.06% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	14.88	-0.94% ▼
Зэс	USD/lb.	263.10	0.13% ▲
Нүүрс	USD/MT	73.00	-2.67% ▼
WTI газрын тос	USD/bbl.	52.51	-2.74% ▼
Brent газрын тос	USD/bbl.	62.01	-2.02% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	2.39	2.14% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. V	7.90%
Бодлогын хүү	2019. V	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. IV	11.02%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. IV	11.83%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. IV	4.95%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. IV	17.11%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. IV	10.57%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 52 компанийн 639.8 сая төгрөгийн 3,199,380 ширхэг хувьцаа арилжигдав.

“Инвескор ББСБ” /INV/ компанийн хувьцаа 14.50%-аар буюу хамгийн ихээр өсөж 1,832.00 төгрөгт хүрч хаагдсан бол “Тахь-ко” /ТАН/ компанийн хувьцаа 13.56%-аар буурч 10,200.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


6-р сарын 10-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,472.4 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,689.76 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.63%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	639,8
Зах зээлийн үнэлгээ	2,472,354.2

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,689.76	0.63% ▲
MSE I индекс	9,061.75	0.18% ▲
MSE II индекс	7,783.69	-0.76% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Инвескор ББСБ	92,369	159,835,337
Монгол базальт	268,942	77,678,431
АПУ	115,723	65,157,534
Монос хүнс	831,936	59,532,210
ЛэндМН ББСБ	968,712	57,849,604

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Инвескор ББСБ	1,832.00	14.50% ▲
Шивээ овоо	1,800.00	12.50% ▲
Монгол шуудан	588.50	9.18% ▲
Монгол савхи	650.00	7.41% ▲
Би Ди Сек	814.00	5.95% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Тахь-ко	10,200.00	-13.56% ▼
Бинсэ	300.00	-11.76% ▼
Хай би ойл	42.00	-10.64% ▼
Монгол шевро	1,800.00	-10.00% ▼
Багануур	1,025	-7.91% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ти Ди Би Капитал	19,701,531,303
Инвескор Капитал	17,226,214,750
Гаули	274,632,659
БиДиСек	261,316,646
Голомт Капитал	239,834,521

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	561.18	597,197
Таван толгой	6,880.00	362,337
МИК	12,500.00	258,867
Говь	285.26	222,535
Инвескор ББСБ	1,832.00	131,406

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
---	-----------------	--------------------	-----------------	------------	------------	---------	-----

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.10.01-с
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.29-ний дотор
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	N/A
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.12.31-ний дотор
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн”-ийн хувьцаа эзэмшигчдийн анхаарал

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” (TSX:ERD | MSE:ERDN) нь 10,000,000 ширхэг нэмэлт үнэт цаасыг тус бүрийг нь 0.20 канад доллараар хаалттай хүрээнд санал болгон худалдах замаар 2 сая канад долларын хөрөнгө татан төвлөрүүлэхээр төлөвлөж байгаа тухай мэдэгдлээ.

Татан төвлөрүүлэх хөрөнгөөр Хөндий Алтны Төслийн хараат бус урьдчилсан ТЭЗҮ боловсруулах, 2019 оны 2-р улиралд илрүүлсэн Баян Хөндийн хүдрийн биетийн тэлэлтийн бүсийн үргэлжлэлийг шалгах өрөмдлөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төслийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргах үйл ажиллагаа болон бусад шаардлагатай хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



СЗХ-ны 2019 оны ээлжит IX хуралдаан болов

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны ээлжит IX хуралдаан 6-р сарын 14-ны өдөр болж нийт 30 асуудал хэлэлцэн шийдвэрлэв.

Үүнээс үнэт цаасны салбарын 4 асуудлыг хэлэлцэж, “Мик актив арван ес” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, тус компанийн гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэв. “Мишээл рийл истэйт фанд” хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бичиг баримтыг бүртгэж, “Махонилиотта” ХХН-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэлээ.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

“Таван толгой” ХК-ийн 2018 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршууллаа

“Тавантолгой” ХК-ийн 2018 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 767.70 төгрөг (татварын дараах) тараасныг 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

Эх сурвалж: Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв



“Инвескор ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхаарал

“Инвескор ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2019 оны 6-р сарын 7-ны өдрийн А/20-Т тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2019 оны 7-р сарын 25-ны өдрийн 14:00 цагт хуралдуулахаар болсон тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурлын тов: 2019 оны 7-р сарын 25-ны 14:00 цагт

Хуралдах газар: Монгол Улс, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж-39, Корпорейт Хотел энд Конвеншн Центрын “Ивент Холл”-д

Бүртгэх өдөр: 2019 оны 7-р сарын 1-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. 2019 оны хагас жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг тайлагнах;
2. Компанийн “Дүрэм”-ийн төслийг батлах;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны төсөв батлах.

Холбоо барих утас: 7709-0077.



“Мон-наб” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхаарал

“Мон-наб” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2019 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 19/15 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2019 оны 7-р сарын 18-ны өдөр хуралдуулахаар боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдах тов: 2019.07.18-ны өдрийн 14:00 цагт

Бүртгэх өдөр: 2019.06.28-ны өдөр

Хуралдах газар: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 хороо, Засгийн Газрын 11-р байр 1206 тоот

Хурлаар хэлэлцэх асуудал: Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.

Хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг: Хувьцаа эзэмшигчид ажлын өдрүүдэд 09:00 - 17:00 цагийн хооронд “Мон-наб” ХК-ийн байранд ирэх эсвэл хурал зохион байгуулах комиссын гишүүдтэй холбогдон материалтай танилцах боломжтой.

Хурал зохион байгуулах комисс: Комиссын дарга Ш.Оюун-Эрдэнэ; гишүүн Д.Болорцэцэг.

Хурал зохион байгуулах комисс: 9191-9392, 7017-2141

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Оны эхний 5 сард чулуун нүүрсний экспорт өмнөх оны мөн үеэс 7 хувиар өсөж, 15.1 сая тонн болжээ

Оны эхний таван сард чулуун нүүрсний экспорт 15.1 сая тонн болж, өнгөрсөн оны мөн үеэс долоон хувиар өссөн байна. Харин мөнгөн дүнгээрээ 15 орчим хувиар өсөж, 1.2 тэрбум ам.доллар болсон талаар Гаалийн ерөнхий газар мэдээллээ.

Тавантолгойн бүлэг ордод олборлолт хийж байгаа компаниудаас “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрсний борлуулалт өнгөрсөн оны мөн үеэс 20 хувиар өсөж, долоон сая тонн болсон байна. Зургаадугаар сарын зургааны байдлаар нүүрсний борлуулалтын орлого 1.26 их наяд төгрөг болсон талаар тус компани мэдээллээ. “Эрдэнэс Тавантолгой” компанийн энэ оны төлөвлөгөө 15 сая тонн байгаа аж.

Нарийнсухайтын бүлэг ордод олборлолт хийж буй компаниудаас “Монголын алт корпораци” оны эхний таван сард 1.7 сая тонн нүүрс экспортложээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспорт тааруухан байгаа нь дотоод хүчин зүйлсээс хамаарч байна гэж тус компанийн тэргүүн дэд Ерөнхийлөгч Г.Цогт мэдээллээ. “Эрдэнэс Тавантолгой” компани 2018 онд долоон сая тонн нүүрс гаргасан бол энэ онд найман сая тонныг экспортлохоор төлөвлөжээ.

Үүнээс гадна “Өсөх зоос” ХХК нүүрс угаах үйлдвэрээ ашиглалтад оруулахаар бэлтгэж байгаа талаараа сүүлд мэдээллээ. Оны эхний таван сарын байдлаар нүүрс экспортлогч компаниудын тухайд хөрөнгө босгох ажил харьцангуй амжилттай байсан юм.

Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй, Баруун Ноён уул ордод олборлолт хийж байгаа “Terracom” компани өнгөрсөн сард 60.9 сая ширхэг хувьцаа нэмж гаргаад 35.34 сая ам.доллар татан төвлөрүүлсэн байна. Тус компани Монголоос олборлож экспортлох нүүрсний хэмжээгээ жилийн гурван сая тонн болгох зорилт тавиад байгаа аж.

Мөн Ухаа худаг, Баруун наран ордуудад нүүрс олборлож байгаа “Энержи Ресурс” буюу “Mongolian Mining Corporation” 2024 онд хугацаа нь дуусах 9.25 хувийн хүүтэй 440 сая ам.долларын бонд амжилттай гаргаж, хөрөнгөө татан төвлөрүүлээд байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

I-V сард боловсруулаагүй газрын тосны экспорт 4 хувиар буурч, 2.62 сая баррель болов

Оны эхний таван сард боловсруулаагүй нефтийн экспорт биет хэмжээгээр дөрөв орчим хувиар буурч, 2.62 сая баррель болсон байна.

Харин нэг баррелийн дундаж ханш нь 57.1 ам.доллар болж буурснаар нийт мөнгөн дүн нь 15 хувиар багасаж, 150 сая ам.доллар болсон талаар Гаалийн ерөнхий газар мэдээллээ. Гол экспортлогч компаниуд болох “Петрочайна дачин тамсаг” 2019 онд нэг сая 50 мянган тонн, “Доншин” компани 50 мянган тонныг экспортлохоор төлөвлөжээ. “Петрочайна дачин тамсаг” компани цаашид олборлолтоо нэмэгдүүлэх зорилгоор хайгуулаа эрчимжүүлэх хүсэлтээ гаргасан болохыг Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээлсэн юм.

2019 онд газрын тосны салбараас улсын төсөвт 223.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр зорьж байна. Газрын тосны хайгуулын тухайд “Петро матад” компани ХХ талбайдаа анхны цооног өрөмдлөг хийхээр төлөвлөж байгаа аж. Дорнод аймгийн Матад, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумыг хамарсан энэхүү талбайд бэлтгэл ажлаа хангаж байгаа талаар тус компани мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



Оны эхний 5 сард голлох эрдэс бүтээгдэхүүнүүдийн экспорт өслөө

2019 оны эхний таван сарын үзүүлэлтээр Монгол Улсын экспортод гаргаж байгаа уул уурхайн түүхий эдүүдийн хэмжээ бүхэлдээ өссөн байна. Энэ нь гадаад зах зээлийн эрэлт сайн байгааг илтгэн харуулж байгаа юм.

Мөн хугацаанд 624.3 мянган тонн зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ-д экспортлосон нь жилийн өмнөхөөс дөрвөн хувиар өссөн байна. Мөнгөн дүнгээр тооцвол 8.5 хувиар өсөж, 893 сая ам.доллар болсон талаар Үндэсний статистикийн хороо мэдээллээ. Гол экспортлогч “Оюу Толгой” ХХК 2019 онд нийт 125-155 мянган тонн баяжмал дахь зэс, 180-220 мянган унци баяжмал дахь алт үйлдвэрлэхээр төлөвлөж байгаа аж. Өнгөрсөн онд тус компани туршилтаар Японд зэсийн баяжмал гаргасан юм. Үндэсний статистикийн хорооны мэдээллийг харвал Японд нийлүүлсэн баяжмалын экспорт 6.9 сая ам.доллар хүрч байжээ.

Харин энэ онд “Шинэ зах зээлээ үргэлжлүүлэн судлах боловч дэд бүтцийн бэрхшээл байгаа” гэдгийг “Оюу Толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал Армандо Торрес онцолж байлаа.

Оны эхний таван сард жоншны экспорт биет хэмжээгээр 44.4 хувиар өсөж, 221.5 мянган тонн болжээ. Мөнгөн дүнгээр тооцвол 48 хувиар өсөж, 74.8 сая ам.доллар болсон талаар Үндэсний статистикийн хороо мэдээллээ.

Жоншны 67 хувийг БНХАУ, 32.5 хувийг ОХУ-д нийлүүлсэн байна. БНХАУ гол зах зээл хэвээрээ байгаа аж. Харин үлдсэн багахан хэсгийг БНСУ-д гаргажээ. БНСУ-ын “Posco” компани Монголын жоншны салбарыг сонирхож байгаа юм. Одоогоор Монголд хайлуур жоншны 20 үйлдвэр байгаагаас ес нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй байгааг Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам мэдээллээ.

Оны эхний таван сард төмрийн хүдрийн экспорт биет хэмжээгээр 26 хувиар өсөж, 3.5 сая тонн болсон байна. Мөнгөн дүнгээр 58 хувиар өсөж, 207.4 сая ам.доллар болсон талаар Үндэсний статистикийн хороо мэдээллээ. Олон улсад нэгдүгээр сарын 25-нд “Vale” компанийн төмрийн хүдрийн уурхайн далан нурснаас хойш нийлүүлэлт тасалдах эрсдэл үүссэн юм. Улмаар төмрийн хүдрийн ханш огцом өссөн нь Монголын экспортлогчдод ч бас мэдрэгдэж эхэлжээ.

Харин цайрын экспорт оны эхний таван сард 24 хувиар өсөж, 64.8 мянган тонн болсон байна. Мөнгөн дүнгээр 3.3 хувиар өсөж, 95.8 сая ам.доллар болсон талаар Үндэсний статистикийн хороо мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

Монгол улсын эдийн засгийн 2019 оны 5-р сарын байдал

Мөнгө, зээл

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2019 оны 5-р сарын эцэст 20.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 385.6 (1.9%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3.2 (19.1%) их наяд төгрөгөөр тус тус өсжээ.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2019 оны 5-р сарын эцэст 939.7 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 6.7 (0.7%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3.9 (0.4%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 5-р сарын эцэст 18.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 314.1 (1.8%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3.0 (20.0%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2019 оны 5-р сарын эцэст 2.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 28.9 (1.5%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 754.2 (61.8%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 11.0 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 2.9 пунктээр өссөн байна.

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш 2019 оны 5-р сард 2,645.16 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.0 хувиар, өмнөх сараас 0.4 хувиар тус тус суларсан байна. Харин төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2019 оны 5-р сард 385.97 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар суларч, өмнөх сараас 1.6 хувиар чангарсан байна.

Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2019 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 4.0 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 3.8 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 146.1 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2019 оны 5-р сард 819.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сараас 148.7 (15.4%) тэрбум төгрөгөөр буурч, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 960.3 тэрбум төгрөгт хүрч, 83.9 (9.6%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 81.5 хувийг татварын орлого, 8.3 хувийг татварын бус орлого, 9.6 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 0.6 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлжээ.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 84.2 хувь, хөрөнгийн зардал 13.8 хувь, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 2.1 хувийг эзэлж байна.

Засгийн газрын нийт өр 2019 оны эхний улиралд 22.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 873.9 тэрбум төгрөг буюу 4.1 хувиар өссөн байна. Засгийн газрын нийт өрийн 18.9 их наяд төгрөг буюу 84.7 хувь гадаад өр, 1.5 их наяд төгрөг буюу 6.9 хувь нь дотоод өр, 1.1 их наяд төгрөг буюу 4.9 хувь нь Засгийн газрын өрийн баталгаа, 807.9 тэрбум төгрөг буюу 3.6 хувь нь концесс байна.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2019 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 369.6 сая америк долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 6.0 сая америк доллараар өсжээ.

Урсгал данс 397.1 сая америк долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 709.0 сая америк доллар, анхдагч орлогын данс 408.3 сая америк долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Хөрөнгийн данс 2019 оны эхний 4 сард 27.5 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 3.7 (15.5%) сая америк доллараар өссөн байна.

Харин санхүүгийн дансны тэнцэл 592.4 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 244.6 (70.3%) сая америк доллараар өсжээ.

Төлбөрийн тэнцэл 2019 оны эхний 4 сард 322.9 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 369.9 сая америк доллараар өссөн байна.

Гадаад худалдаа

Монгол Улс 2019 оны эхний 5 сард дэлхийн 135 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 5.6 тэрбум америк доллар, үүнээс экспорт 3.3 тэрбум америк доллар, импорт 2.3 тэрбум америк долларт хүрлээ. Харин 2019 оны 5 дугаар сард экспорт 751.4 сая америк долларт, импорт 548.8 сая америк долларт хүрч, өмнөх сараас экспорт 11.1 сая америк доллараар, импорт 68.3 сая америк доллараар тус тус өсжээ.

Гадаад худалдааны тэнцэл 2018 оны эхний 5 сард 706.4 сая америк долларын ашигтай гарч байсан бол 2019 оны эхний 5 сард өмнөх оны мөн үеэс 241.9 сая америк доллараар өсөж, 948.3 сая америк долларт хүрчээ. Гадаад худалдааны тэнцэл 2019 оны 5 дугаар сард 202.6 сая америк долларын ашигтай гарч, өмнөх сараас 57.3 сая америк доллараар буурсан байна.

Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 5-р сард улсын хэмжээнд өмнөх сараас 1.4 хувь, өмнөх оны эцсээс 4.2 хувь, өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 5-р сард өмнөх оны эцсээс 4.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 14.1 хувь (мах, махан бүтээгдэхүүн 37.3 хувь), хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 2.9 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 2.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 5-р сард өмнөх сараас 1.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 4.2 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.5 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.